




**Арилжааны мэдээ**


- Монголын хөрөнгийн бирж 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс 2019 оны 6 дугаар сарын 14-ний өдрүүдэд 5 удаагийн үнэт цаасны арилжааг зохион байгуулж, өдөрт дунджаар 127 сая төгрөг буюу нийт 639,774,131.82 төгрөгийн арилжаа хийсэн байна.
- 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,472,354,158,944.98 төгрөг болсон бол “ТОП 20” индекс 19689.76 нэгж болж өмнөх долоо хоногоос 0.63% хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**MSE Top 20 индекс**



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

**Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа**



Эх сурвалж: Монгол Банк

**Зах зээлийн өөрчлөлт**

Индекс	Нэгж	% Өөрчлөлт
MSE Top-20 индекс	19689.76	0.63%
MSE A индекс	9061.75	0.18%
MSE B индекс	7783.69	-0.76%

Зах зээлийн хураангуй	Нийт (MNT)
Зах зээлийн үнэлгээ	2,472,354,158,944.98
Арилжигдсан үнийн дүн	639 сая төгрөг

Үнийн дүнгээр	Хаалт (MNT)	Мөнгөн дүн
Инвекор ББСБ	1,832.00	159,835,337.00
МОНГОЛ БАЗАЛТ ХК	290.00	77,678,431.00
АПУ	561.18	65,157,533.97
МОНОС ХҮНС	71.72	59,532,210.12
ЛЭНДМН ББСБ ХК	59.71	57,849,604.43

Тоо ширхэгээр	Хаалт (MNT)	Нийт
ЛЭНДМН ББСБ ХК	59.71	968,712.00
МОНОС ХҮНС	71.72	831,936.00
АРД КРЕДИТ ББСБ ХК	69.43	501,395.00
МОНГОЛ БАЗАЛТ ХК	290.00	268,942.00
АЙТҮҮЛС	84.60	121,401.00

Ханш өссөн	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
Инвекор ББСБ	1832	14.50
ШИВЭЭ ОВОО	1800	12.50
МОНГОЛ ШУУДАН ХК	588.5	9.18
МОНГОЛ САВХИ	650	7.41
БИ ДИ СЕК	814	5.95

Ханш буурсан	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
ТАХЬ-КО	10200	-13.56
БИНСЭ ХК	300	-11.76
ХАЙ БИ ОЙЛ	42	-10.64
МОНГОЛ ШЕВРО	1800	-10.00
БАГАНУУР	1025	-7.91

**Тодруулга**

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.



**ЭНЭ ДОЛОО ХОНОГ**

**“ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН”-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРЛАД (mse.mn)**

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX:ERD | MSE:ERDN) нь 10,000,000 ширхэг нэмэлт үнэт цаасыг тус бүрийг нь 0.20 канад доллараар хаалттай хүрээнд санал болгон худалдах замаар 2 сая канад долларын хөрөнгө татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа тухай мэдэгдлээ.

Татан төвлөрүүлэх хөрөнгөөр Хөндий Алтны Төслийн хараат бус урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, 2019 оны 2-р улиралд илрүүлсэн Баян Хөндийн хүдрийн биетийн тэлэлтийн бүсийн үргэлжлэлийг шалгах өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргах үйл ажиллагаа болон бусад шаардлагатай хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

Монгол хэл дээрх хэвлэлийн мэдээний дэлгэрэнгүйг **Энд** дарж үзнэ үү.  
Англи хэл дээрх хувилбарыг **Энэ** линкээр авна уу.

**“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН 2018 ОНЫ НОГДОЛ АШГИЙГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ДАНСАНД БАЙРШУУЛЛАА. (schcd.mn)**

“Тавантолгой” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 767 төгрөг 70 мөнгө тараасныг 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

**“ШАРЫН ГОЛ” ХК 2020 ОНЫ VI САР ХҮРТЭЛХ ХУГАЦААНД 1.82 САЯ ТОНН НҮҮРС БОРЛУУЛАХААР ТӨЛӨВЛӨЖЭЭ. (bloombergtv.mn)**

Монголын Хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй “Шарын гол” ХК 2019-2020 оны зургаадугаар сар хүртэлх жил хагасын хугацаанд 1.89 сая тонн нүүрс олборлож, 1.82 сая тонныг борлуулахаар төлөвлөж байгаа талаар үйл ажиллагааны тайландаа дурдлаа.

Тус компани 2018 онд хойд бүс буюу Дархан, Эрдэнэтийн эрчим хүчний үйлдвэрүүдийн хэрэгцээг хангаж, олборлосон нүүрснийхээ 75-80 хувийг эрчим хүчний хэрэглээнд нийлүүлсэн байна. Өнгөрсөн онд нүүрсний олборлолт нь 2.4 хувиар өсөж, 1.08 сая тонн болжээ.

Харин борлуулалт нь 3.5 хувиар өсөж, 1.07 сая тонн болсон байна. Улмаар нийт борлуулалтын орлого нь 48.6 тэрбум төгрөг болж үл ялиг буурчээ. Татварын дараах цэвэр ашиг нь мөн л огцом буурч, 38.9 сая төгрөг болсон талаар санхүүгийн тайландаа дурдсан байна.

“Шарын гол” ХК-ийн зах зээлийн үнэлгээ 16.2 тэрбум төгрөг байгаа юм. Өнөөдрийн байдлаар Монголын Хөрөнгийн биржид нийт 10.1 сая ширхэг хувьцаа арилжаалж байна.

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо нь 1016 байгаагийн зургаа нь таваас дээш хувийг эзэмшиж байгаа аж. Сүүлийн нэг жилийн хугацаанд хувьцааных нь ханш 30 хувиар буурч, 1600 төгрөг болжээ.

**“АРД ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРЛАД. (mse.mn)**

“Ард Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн №2/19 тоот тогтоолоор баталсан ногдол ашгийг 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн компанийн төв оффис болон Сэнтрал тауэрт байрлах салбараар дамжуулан хүсэлт гаргаснаар өөрийн дансанд хүлээн авах боломжтой болсон бөгөөд хүсэлт гаргаагүй хувьцаа

эзэмшигчдийн ногдол ашгийг 2019 оны 6-р сарын 28-ны өдрөөс хойш “ҮЦТХТ” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар болсон байна.

**МОНГОЛ НООЛУУРЫГ ДЭЛХИЙН БРЭНД ҮЙЛДВЭРЛЭГЧИД СОНИРХОЖ БАЙНА.(mse.mn)**

Монгол Улс байгальд ээлтэй, тогтвортой аргаар ноолуур бэлтгэсэн тохиолдолд Gucci, H&M, UNIQLO зэрэг дэлхийн томоохон брэндүүд хамтарч ажиллахад бэлэн байгаагаа мэдэгдлээ.

Дээрх компаниудын төлөөлөл манай улсад ирээд байгаа бөгөөд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газар, ХХААХҮЯ-наас хамтран өнөөдөр зохион байгуулсан “Монгол Улсад байгаль орчинд ээлтэй ноолуур үйлдвэрлэлийг дэмжих тогтолцооны өөрчлөлт” сэдэвт хэлэлцүүлэгт оролцох үеэрээ ийнхүү мэдэгдсэн юм. Байгаль орчинд ээлтэй ноолуурын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Монгол Улсад ийм санаачилгыг дэмжих зорилгоор тус хэлэлцүүлгийг зохион байгуулжээ.

Хэлэлцүүлгийг нээж, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгч, хатагтай Биата Транкман хэлэхдээ “Дэлхий дахинаа ноолуурын бөөний үйлдвэрлэлээс татгалзаж, бүтээгдэхүүн хийх явцад байгаль орчин, ан амьтан, үйлдвэрлэгчийн амьжиргаа зэргийг цогцоор нь харгалзан үздэг болсон” гэдгийг тодотгоод, “Ийм цаг үед олон зуун жилээр байгаль орчинтойгоо ойр, таван хошуу малаа маллаж ирсэн, уламжлалт мал аж ахуй эрхлэлтийн үнэ цэнийг дэлхийд таниулах боломж Монголд байна” гэдгийг онцолж байв.

“H&M” брэндийн Ази дахь салбарын төлөөлөгч Шерри Гү хэлэхдээ, “Манай брэнд дэлхийд бэлэн хувцасны үйлдвэрлэлээр гуравт ордог. Сүүлийн үед дэлхийн томоохон брэндүүд амьтны эрхийг зөрчсөн, байгальд ээлгүй үйлдвэрлэлээс татгалзаж эхэлж байна. Энэ нь гэхдээ ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэхийг бүрэн болино гэсэн үг биш. Монгол Улсын хувьд ноолуурыг байгаль орчинд ээлтэй, эрүүл малаас түүхий эдээ авч, ингэхдээ хүүхдээр хөдөлмөр эрхлүүлээгүй зэрэг байдлаар ноос ноолуураа тогтвортой бэлтгэж байвал бид Монгол ямааны ноолуурыг өндөр үнээр авахад бэлэн байна” гэдгээ илэрхийлсэн юм.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ХАА-н бүтээгдэхүүний ногоон үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн захирал Эндрю Баварник хэлэхдээ, “Өнөөдөр бид уулзаж байгаа нь төр, хувийн хэвшил, дотоодын компани, малчид хамтарч ажиллах талбарыг (платформ) бий болгох явдал юм. Дотоодын үйлдвэрлэгчид олон улсын зах зээлд бүтээгдэхүүнээ гаргаж, ашигтай ажиллах боломж байгаа нь харагдсан. Ингэхийн тулд хамтарч ажиллах хэрэгтэйг сануулж байна”.

Манай улс дэлхийн ноолуурын нөөцийн 40 хувийг бэлтгэн гаргадаг. Өнгөрсөн жилээс эхлэн “Ноолуур” хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд 1570 ажлын байр бий болж 2018 онд гэхэд 1.3 их наяд төгрөгийн борлуулалт хийснийг албаныхан онцолж байв. Хэлэлцүүлэгт НҮБХХ-ийн ХАА-н бүтээгдэхүүний ногоон үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн төлөөлөл, Монголын ноос ноолуурын холбоо, AVSF байгууллага, Тогтвортой ноос ноолуурын эвсэл, Textile Exchange олон улсын сүлжээ, дэлхийн тансаг бүтээгдэхүүний брэндүүдийг эзэмшдэг Kering групп, эрдэм шинжилгээний байгууллага, судлаачид зэрэг олон талын төлөөлөл оролцлоо.



**О.Уранбайгаль**

Харилцагчийн албаны менежер  
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-7555-1919  
Факс: 976-11-321763

**Д.Шүрэнцэцэг**

Харилцагчийн алба, мэргэжилтэн  
И-мэйл: shurentsetsegd@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-7555-1919  
Факс: 976-11-321763

**Б.Онон**

Харилцагчийн алба, мэргэжилтэн  
И-мэйл: Onon.b@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-7555-1919  
Факс: 976-11-321763

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.